



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

### Хаалттай өрийн хэрэгсэл бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инвескор ББСБ” ХК-ийн хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 1,000,000 /нэг сая/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 10,000 /арван мянга/ ширхэг өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т зөвшөөрсүгэй.

2. Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Инвескор ББСБ” ХК /Д.Баясгалан/-д үүрэг болгосугай.


1/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, харилцагч, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн ажиллах;

2/ Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3-т тус тус заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс өрийн хэрэгслийн хүүгийн хэмжээг тогтоож, арилжаалахаас өмнө тухай бүр шийдвэрийг Хороонд ирүүлэн мэдэгдэж байх;

3/ Хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, үлдэгдэл, эргэн төлөлтийн талаарх мэдээллийг Хороонд улирал тутам ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН